

- 1 ▶ **Асуулт:** Бодис нь зөвшөөрөгдсөн эсэхийг би хэрхэн мэдэх вэ?
- Хэрэв та бодисыг эмийн сангаас худалдан авсан бол энэ ав хэрэглэхэд аюулгүй.
 - Хэрэв бодис нь хайрцаг дээрээ "сэргээш байхгүй" гэсэн бол энэ нь хэрэглэхэд аюулгүй.
 - Хэрэв бодисыг ургамлаар хийсэн бол энэ нь хэрэглэхэд аюулгүй.
 - Хэрэв бодис нь хориглосон бодисын жагсаалт дээрх аливаа бодисыг агуулаагүй бол энэ нь хэрэглэхэд аюулгүй.

Хариулт: d. Хэрэв бодис нь хориглосон бодисын жагсаалт дээрх аливаа бодисыг агуулаагүй бол энэ нь хэрэглэхэд аюулгүй.

Тайлбар: Та бодисыг хэрэглэхийг хүссэн эсвэл хэрэглэх хэрэгтэй үедээ хориглосон бодис ба аргын жагсаалтыг шалгаж байгаарай. Хэрэв та итгэлтэй биш бол жагсаалтыг эмийн санч эсвэл эмчид үзүүлж, асуугаарай. Та жагсаалтыг ДСЭА-ын цахим хуудас, үндэсний сэргээшний эсрэг байгууллагын (ҮСШБ) эсвэл өөрийн олон улсын холбооны (ОУХ) цахим хуудаснаас олох боломжтой. Та мөн ҮСШБ эсвэл ОУХ-тай холбогдож, асуух боломжтой.

- 2 ▶ **Асуулт:** Тэжээлийн нэмэгдлүүд нь ашиглахад аюулгүй эсэхийг та хэрхэн хэлж чадах вэ?
- Бүх тэжээлийн нэмэгдэл нь хэрэглэхэд аюулгүй.
 - Тэжээлийн нэмэгдэл нь хэрэглэхэд аюулгүй эсэхийг тал хэлж чадахгүй
 - Хэрэв шошго нь аюулгүй гэж хэлсэн бол
 - Хэрэв эмч үүнийг танд өгсөн бол

Хариулт: b. Тэжээлийн нэмэгдэл нь хэрэглэхэд аюулгүй эсэхийг тал хэлж чадахгүй

Тайлбар: Нэмэлтийн үйлдвэр нь зохицуулагддаггүй бөгөөд нэмэлтэд ямар бодис/найрлага байгаа талаар та итгэлтэй байж чадахгүй. Нэмэлтийг хэрэглэх нь ямагт таны өөрийн эрсдэл юм. Х Хэрэв савлагаа дээрх баталгаа нь дэндүү сайн гэдэг нь үнэн юм шиг санагдвал энэ нь спортод хориглосон бодисыг агуулсан байж магадгүй.

- 3 ▶ **Асуулт:** Би тест өгч болох уу?
- Үгүй, учир нь би насанд хүрээгүй
 - Үгүй, учир нь би олон улсад өсөлдөггүй
 - Тийм, аливаа тамирчин тест өгөх боломжтой байх ёстой
 - Үгүй, яагаад гэвэл миний спорт бол өндөр эрсдэлтэй спорт биш юм

Хариулт: c. Тийм, аливаа тамирчин тест өгөх боломжтой байх ёстой

Тайлбар: Сэргээшний эсрэг дүрмийг бүх тамирчин, бүх спорт, бүх улс мөрдөнө. Түүнчлэн, аливаа тамирчин тест өгөх ёстой.

- 4 ▶ **Асуулт:** Хэрэв би сэргээш хэрэглэж байгаад баригдсан бол ямар шийтгэлтэй вэ?
- Сэргээшинд зориулсан шийтгэл байхгүй
 - Хэрэв би насанд хүрээгүй бол шийтгэл байхгүй
 - Сануулахаас эхлэн насан туршийн хориг хүртэл
 - Бодисыг танд хэн өгснөөс шалтгаална

Хариулт: c. Сануулахаас эхлэн насан туршийн хориг хүртэл

Тайлбар: Шийтгэлд үр дүнг хэрэгсэхгүй болгох, бүх спортод өрсөлдөхийг хориглох, санхүүгийн шийтгэл болон таны сэргээшний эсрэг дүрмийн зөрчлийг заавал хэвлэх ажиллагаа багтах бөгөөд эдгээр шийтгэл нь зөрчлийн ноцтой байдлаас хамаарна.

- 5 ▶ **Асуулт:** Миний дасгалжуулагч эсвэл эмч шийтгэл хүлээх үү?
- Үгүй, зөвхөн тамирчид шийтгэгдэнэ
 - Үгүй, зөвхөн тамирчид ба дасгалжуулагчид шийтгэгдэнэ
 - Үгүй, сэргээшинд шийтгэл байхгүй
 - Тийм, Бүх тамирчид ба бүх тамирчинд дэмжлэг үзүүлэгчид шийтгэгдэнэ

Хариулт: d. Тийм, Бүх тамирчид ба бүх тамирчинд дэмжлэг үзүүлэгчид шийтгэгдэнэ

Тайлбар: Дэлхийн сэргээшний эсрэг дүрмийн (дүрэм) дагуу тамирчид ба тамирчинд дэмжлэг үзүүлэгч ажилтан нь сэргээшний эсрэг дүрмийг зөрчсөн бол адилхан шийтгүүлэх болно. Тамирчинд дэмжлэг үзүүлэгч ажилтанд спортын тэмцээнд тамирчныг оролцох эсвэл бэлтгэхэд хамтран ажилладаг эсвэл эмчилдэг аливаа дасгалжуулагч, сургагч, менежер, агентлаг, багийн гишүүд, албаны хүн, эмнэлгийн эсвэл пара эмнэлгийн ажилтан багтана.

6 ▶ **Асуулт:** Тамирчны биеэс бодис илэрсэн үед хэн хариуцлага хүлээх вэ?

- Тамирчны эмч
- Тамирчны дасгалжуулагч
- Тамирчин
- Бодисыг тамирчинд хэн өгснөөс шалтгаална

Хариулт: с. Тамирчин

Тайлбар: Хэрэв хориглосон эмийг санамсаргүйгээр хэрэглэсэн эсвэл хэн нэгэн бодисыг аюулгүй гэж хэлэн өгсөн байсан ч гэсэн тамирчин өөрийн биед илэрсэн зүйлийг хариуцна. Үүнийг хатуу хариуцлагын зарчим гэж нэрлэдэг. Хэрэв тамирчин бодисын найрлагын ба статусын талаар 100 хувь итгэлтэй биш бол хориглосон жагсаалтыг шалгах болон өөрийн олон улсын холбооноос (ОУХ) эсвэл үндэсний сэргээшний эсрэг байгууллагаас (ҮСШБ) асуухаас өмнө бодисыг хэрэглэх ёсгүй.

7 ▶ **Асуулт:** Миний эмч ямар нэг эмээр намайг эмчилсэн бол яах вэ?

- Эм нь хориглосон бодис агуулсан эсэхийг эмч шалгах ёстой
- Миний эмчийн өгсөн бүх зүйл аюулгүй
- Хэрэв миний эмчийн өгсөн бодисоос болж тестийн үр дүн зэрэг гарсан бол энэ нь тэр эмэгтэй/эрэгтэйн буруу
- Хэрэв энэ нь эмчилгээний шалтгаантай бол шаардлагатай бүхнийг би ууж болно

Хариулт: а. Эм нь хориглосон бодис агуулсан эсэхийг эмч шалгах ёстой

Тайлбар: Эм нь хориглосон бодис агуулсан эсэхийг эмч шалгах ёстой. Хэрэв хориглосон бодис агуулсан бөгөөд бусад боломжтой эмчилгээ байхгүй бол тамирчин нь эмчилгээг нотолсон баримт бүхий эмчилгээний чөлөөлтийг хүсэх ёстой. Эмч нар энэ процессын талаар үргэлж мэддэггүй тул та тамирчин бөгөөд тодорхой сэргээшний эсрэг дүрэм танд үйлчилдэг гэдгийг эмчдээ хэлэх нь маш чухал юм.

8 ▶ **Асуулт:** Миний сонгосон дасгалжуулагч эсвэл хэн нэгэн надтай хамт сэргээшний хяналтын төв дээр очиж болох уу?

- Тийм
- Зөвхөн би насанд хүрээгүй бол
- Зөвхөн сэргээшний хяналтын ажилтан төлөөний хүнийг байлгахын хүссэн бол
- Тамирчин нь хяналтын станц руу хэзээ ч хэн нэгнийг дагуулж явж болохгүй

Хариулт: а. Тийм

Тайлбар: Тамирчныг эцэг эх, дасгалжуулагч, багийн албаны хүн эсвэл эмч зэрэг хэн нэгэн хэрэв тэр эмэгтэй/эрэгтэй хүсвэл сэргээшний хяналтын төв рүү дагалдан явж болно. Бүх насанд хүрээгүй тамирчид хэн нэгэнтэй хамт сэргээшний хяналтын төв дээр байх ёстой. Хэрэв тамирчныг хэн ч дагалдах боломжгүй бол сэргээшний хяналтын төв тэр эмэгтэй/эрэгтэйг дагалдах хэн нэгнийг сонгож болно. Хэрэв шаардлагатай бөгөөд боломжтой бол тамирчин нь хэлний тусламж эсвэл хэлмэрчтэй байж мөн болно.

9 ▶ **Асуулт:** Хэнийг сэргээшний хяналт хийхийг зөвшөөрдөг вэ?

- Сэргээшний эсрэг байгууллагаас олгосон зөвшөөрлийн нотолгоо болон тодорхойлолтыг харуулж чадах сэргээшний хяналтын ажилтан
- Аливаа дасгалжуулагч
- Аливаа эмч
- Аливаа цагдаагийн ажилтан

Хариулт: а. Сэргээшний эсрэг байгууллагаас олгосон зөвшөөрлийн нотолгоо болон тодорхойлолтыг харуулж чадах сэргээшний хяналтын ажилтан

Тайлбар: Зөвхөн итгэмжлэгдсэн сэргээшний хяналтын ажилтанд сэргээшний хяналтын процессыг үргэлжлүүлэхийг зөвшөөрнө. Тэр эмэгтэй/эрэгтэй нь сэргээшний хяналтын ажилтан бөгөөд сэргээшний эсрэг байгууллагаас сэргээшний хяналтыг авч явуулах эрх олгосон гэдгийг нотлох ёстой.

- 10 ▶ Асуулт:** Сэргээш нь миний өсөлтөд нөлөө үзүүлэх үү?
- Тийм, сэргээшний бодис нь таны өсөлтөд шууд нөлөө үзүүлнэ
 - Үгүй, энэ нь танд зөвхөн маш муу батга өгнө
 - Үгүй, энэ нь та маш их хөгширсөн үед зөвхөн нөлөө үзүүлнэ
 - Үгүй, энэ нь зөвхөн дотор эрхтэнд нөлөө үзүүлнэ

Хариулт: а. Тийм, сэргээшний бодис нь таны өсөлтөд шууд нөлөө үзүүлнэ

Тайлбар: Сэргээш нь маш олон харш нөлөөтэй байж болно. Нэг боломжит харш нөлөө нь таны өсөлт ба биеийн хөгжилд нөлөө үзүүлэх явдал юм. Боломжит харуу үйлдлүүдэд дурдагдсан бусад бүх харш нөлөө нь мөн үнэн юм. Сэргээшний бодис нь таны эрүүл мэндэд ноцтой сөрөг үр дагавартай байж болох учраас тэдгээрийг тодорхой хэмжээнд хориглодог.

- 11 ▶ Асуулт:** Би тест өгөхөөс татгалзаж болох уу?
- Үгүй
 - Тийм, надад гэр бүлийн амлалт байгаа бол
 - Тийм, би маш их завгүй бол
 - Тийм, та сургуулийн үүрэгтэй бол

Хариулт: а. Үгүй

Тайлбар: Тамирчид сэргээшний хяналт руу явуулахаас татгалзаж чадахгүй. Татгалзалд тестийн эерэг хариутай адил шийтгэлийг ноогдуулах болно. Жишээ нь бүх спортын боломжит хориг. Яагаад ингэдэг вэ гэвэл сэргээш хэрэглэсэн тамирчин тест өгөхөөс хялбархан татгалзаж чадах бөгөөд хэзээ ч баригдахгүй, шийтгэгдэхгүй байх боломжтой.

- 12 ▶ Асуулт:** Сэргээшний эсрэг найдвартай мэдээллийг би хаанаас олж чадах вэ?
- Олон улсын холбоо, Үндэсний сэргээшний эсрэг байгууллага, Дэлхийн сэргээшний эсрэг агентлаг
 - Интернет
 - Хүч тамир ба спортын сэтгүүл
 - Миний найзууд

Хариулт: а. Олон улсын холбоо, Үндэсний сэргээшний эсрэг байгууллага, Дэлхийн сэргээшний эсрэг агентлаг

Тайлбар: Хориглосон жагсаалтын талаарх асуултуудад хариулах, хаашаа илгээх болон эмчилгээний чөлөөлтийн өргөдөл гаргах зэргийг багтаасан сэргээшний хяналтын бүх асуудлаарх мэдээллийг Олон улсын холбоо (ОУХ), Үндэсний сэргээшний эсрэг байгууллага (ҮСЭБ), Бүсийн сэргээшний эсрэг байгууллага (БСЭБ), Үндэсний олимпын хороо болон Үндэсний холбоо нь тамирчдад өгч чадна. Дэлхийн сэргээшний эсрэг агентлаг (ДСЭА) нь мөн мэдээллийн эх үүсвэр юм.

- 13 ▶ Асуулт:** сэргээшний хяналт хэрхэн явагддаг вэ?
- сэргээшний хяналтын ажилтан дээж өгөх ёстой гэж надад мэдэгдсэн
 - Би үснээсээ заримыг өгөх ёстой.
 - Би зүүн тохойгоо баруун өвдөг дээр тавиад өлмийдөх ёстой
 - Дээрх бүгд

Хариулт: а. сэргээшний хяналтын ажилтан дээж өгөх ёстой гэж надад мэдэгдсэн

Тайлбар: "сэргээшний хяналтад зориулж таныг сонгосон үед сэргээшний хяналтын ажилтан тань дээр ирнэ. Та тэр эмэгтэй/эрэгтэйтэй хамт сэргээшний хяналтын төв рүү явна. Бага зэргийн бичиг цаасны ажил байх бөгөөд та дээжийг авах хэрэгслийг сонгоно (2 шилэн сав ба аяга бүхий хайрцаг). Тэгээд та угаалгын өрөө рүү явах ба тантай ижил хүйстэй хэн нэгний өмнө аяга руу шээнэ (шээс нь таных мөн гэдгийг нягтлахын тулд). Зарим тохиолдолд танаас цусны дээж өгөхийг асууж магадгүй. Дараа нь та сэргээшний хяналтын төв рүү буцаж явах ба авсан шилэн саваа бөглөөд, лацадна. Бага зэрэг илүү бичиг цаасны ажил, тэгээд дуусна! 1-2-3 шиг хялбар!"